



Үндэсний Аудитын газар болон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

УЛС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ
/ГАГ-2018-01-ГА, ГАГ-ДОА-2018-01-ГА/



Хариуцлагагүй байдлаас шалтгаалж чанаргүй,
үр дүнгүй ажлууд хийгдсэн байна.

Чойбалсан хот

2018 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын алба

Дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Б.Болортуул
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584207

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа
Утас: 70584207

Аудитор
М.Ухаанбилэг,
Я.Зориг
Гэрээт аудитор
З.Гансүх,
Г.Хонгорзул
Утас: 70584207

2018 оны 05 дугаар сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын утас,
70584203 дугаарын
факсаар харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. Хөрөнгө оруулалтын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил давтагдсаар байна.

1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.

1.2. Зураг, төсөв хийгдээгүй төсөл арга хэмжээ батлагдсаар байна.

1.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан байна.

II Бүлэг. Хариуцлагагүй байдлаас шалтгаалж чанаргүй, үр дүнгүй ажлууд хийгдсэн байна.

2.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны 95.6 хувь нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан байна.

2.2. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих зохиогчийн хяналтыг сайжруулж, зураг төсвийг боловсруулахдаа хэрэглэгчийн саналыг харгалзах шаардлагатай байна.

2.3. Гүйцэтгэгч компаниуд гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй тохиолдлууд гарсан байна.

2.4. Захиалагч гэрээний хэрэгжилтэд хяналтыг бүрэн тавьж ажиллаагүй байна.

2.5. Аймгийн ЗДТГ нь санхүүжилтийг олгохдоо СС-ын 2016 оны 415-р журмыг баримтлахгүй байна.

III Бүлэг. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

3.1. Хөрөнгө оруулалтын 2017 оны зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

3.2. Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд сүүлийн 2 жил дотоод хяналт хийгдээгүй байна.

3.3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

ДҮГНЭЛТ
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ
САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР
ЗӨВЛӨМЖ
АЛБАН ШААРДЛАГА
ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГ	Засгийн газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗД	Засаг дарга
ГХБХБГ	Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ЗТБХБС	Зам Тээврийн Барилга хот байгуулалтын Сайд
ЗТАЖЯ	Зам Тээврийн аялал жуулчлалын яам
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БТСГ	Биеийн тамир, спортын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СС	Сангийн сайд
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл

ТАХ	Төсөл, арга хэмжээ
ББН	Бүрэн бус нөхөрлөл
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХО	Хөрөнгө оруулалт
БСШУС	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Сайд
БОЭТ	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Аудитаар Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ.

- *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх,*
- *Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх,*
- *Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бодитой тооцож, үнэлсэн эсэх.*

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумдын ЗДТГ хамрагдлаа. Аймгийн болон 8 сумдын хөрөнгө оруулалтын ажлыг объект дээр нь үзэж ашиглагч тал, холбогдох ажилтнуудтай ярилцлага хийлээ.

Үндсэн мэдээлэл:

Дорнод аймагт 2017 онд Монгол Улсын төсвийн тухай хуулиар эрх нь шилжиж ирсэн 1,0 тэрбум төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ, аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,9 тэрбум төгрөгийн 32 төсөл, арга хэмжээг тус тус төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, санал асуулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, бодит байдал дээр оршин байгааг үзэх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төсвийн тухай хууль /5.1.1-5.1.5, 6.6.3, 24.4, 25.1, 28.3, 28.6, 29, 34.1.1-34.1.5, 41, 43.6, 69.1/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль /11.1.1, 17.1, 21.1, 40, 47.1, 47.2, 48, 49/
- Барилгын тухай хууль /12.1.1, 16.1, 22, 25.5, 32.1.11, 37.1.3, 37.4/
- Газрын тухай хууль /12.1, 13.1, 17.1.2, 27.1-27.3, 29.6, 30.1, 31.4, 34.11, 47.1, 47.2, 50.1.2/
- Хот байгуулалтын тухай хууль /12.8, 14.1-14.7, 15.1, 21.1, 22.1/
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам" /3.6, 3.7, 4.14, 4.27, 4.3/
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" /2.1-2.6, 2.11, 3.1-3.5/
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор М.Ухаанбилэг, Я.Зориг, гэрээт аудитор З.Гансүх, Г.Хонгорзул нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдөр эхэлж 04 дүгээр сарын 20-ны өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

I Бүлэг. Хөрөнгө оруулалтын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил давтагдсаар байна.

А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.

1. Дорнод аймагт 2017 онд хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд нь улс болон орон нутгийн салбарын бодлогын баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг үзэхэд дараах байдалтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

Улсын төсвөөс Дорнод аймагт эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээнүүдийн 72,2 хувь нь нийгмийн салбарт буюу боловсрол, эрүүл мэндийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэхээр төлөвлөгдсөн байна.

МУ-н Хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөрт тусгагдсан төслүүд 30,0 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй барилга байгууламж, эдийн засгийн үр өгөөж өгөх томоохон хөрөнгө оруулалтын ажлуудыг тусгадаг учраас Дорнод аймагт 2017 онд хийгдэх төсөл, арга хэмжээнүүд уг хөтөлбөрт тусгагдаагүй байна.

Нийт 18 арга хэмжээнээс улсын болон салбарын хөрөнгө оруулалтын бодлого, МУ-н тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, МУЗГ-н 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, МУ-н мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний цогц бодлого баримт бичигт тусгагдаагүй батлагдсан 2 төсөл, арга хэмжээ байгаа нь нийт ажлын 11,1 хувийг эзэлж байна. Үүнд:

1. Баяндун сумын ЗДТГ-ын автомашин /35,0 сая төгрөг/
2. Цагаан-Овоо, Булган, Чойбалсан, Халхгол, Баян-Уул сумын эмнэлэгт мотоцикл /9,0 сая төгрөг/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүлсэн саналын жагсаалтад дараах 3 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна. Үүнд:

1. Аймгийн төв номын сангийн засварын ажил /Хэрлэн сум, Төв номын сан/ /6,0 сая төгрөг/
2. Хөгжим худалдан авах /Хэрлэн сум, Аймгийн хөгжимт драмын театр/ /8,3 сая төгрөг/
3. Баяндун сумын ЗДТГ-ын автомашин /35,0 сая төгрөг/

Орон нутгийн хөрөнгө оруулалт:


Дорнод аймгийн хэмжээнд 2017 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдаж, батлагдсан байх шаардлагатай.

Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан нийт 32 төсөл арга хэмжээнээс дараах 2 төсөл, арга хэмжээ нь дээрх баримт бичгүүдэд тусгагдаагүй байна. Үүнд:

1. Цас, шороо шүүрдэх төхөөрөмж /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ /20,0 сая төгрөг/
2. Аймгийн онцгой байдлын газарт автомашин худалдан авах хөрөнгийн орон нутгаас гаргах дэмжлэг /25,0 сая төгрөг/

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, бусад бодлогын баримт бичигт тусгагдаагүй батлагдсан төсөл, арга хэмжээнүүд 2016 онд нийт 48 төсөл, арга хэмжээний 34,0 хувийг эзэлж байсан бол 2017 онд уг зөрчил давтагдсан хэвээр байгаа бөгөөд 32 арга хэмжээний 19,0 хувийг эзэлж байна.

Дүрслэл №1




2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрэмбэлсэн саналд дараах 15 төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна. Үүнд:

1. Орон сууцны барилгуудын дээврийн засвар /Халхгол сум/ /52,0 сая төгрөг/
2. Боомт орчмын дэд бүтцийг сайжруулах, тохижуулах /50,0 сая төгрөг/
3. Дорнод аймгийн аялал жуучлалын мастер төлөвлөгөө боловсруулах /БОАЖГ/ /35,0 сая төгрөг/
4. Дорнод аймгийн төрийн байгууллагуудын ажлын гүйцэтгэл, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах цогц программ /50,0 сая төгрөг/
5. Найрамдал цэцэрлэгт хүрээлэнгийн орчмыг камержуулах /Хэрлэн сум/ /13,1 сая төгрөг/
6. Аймгийн залуучуудын нэгдсэн мэдээллийн сайт хийх /ГБХЗХГазар/ /10,0 сая төгрөг/
7. Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг сумдын нэгдсэн цахим хуудас хийх /12,0 сая төгрөг/
8. АЗДТГ-ын Архивын тасагт шаардлагатай тоног төхөөрөмж /15,0 сая төгрөг/
9. Хурал, зөвлөгөөний танхимын тохижилт /АЗДТГ/ /25,0 сая төгрөг/
10. "Нэг цонхны үйлчилгээ"-ний цэгт шаардлагатай тоног төхөөрөмж /Улсын бүртгэлийн хэлтэс/ /5,7 сая төгрөг/
11. Хог тээврийн автомашинд, ачих төхөөрөмж суурилуулах /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ /20,0 сая төгрөг/
12. Явган замын хавтан үйлдвэрлэх тоног төхөөрөмж /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ /10,0 сая төгрөг/
13. Цас, шороо шүүрдэх төхөөрөмж /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ /20,0 сая төгрөг/
14. Зөөврийн ариун цэврийн байгууламж /Хэрлэн сум/ /30,0 сая төгрөг/
15. Аймгийн онцгой байдлын газарт автомашин худалдан авах хөрөнгийн орон нутгаас гаргах дэмжлэг /25,0 сая төгрөг/

Төсөвт байгууллага болон сумдаас ирүүлсэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэхдээ, хурлаар хэлэлцэж ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон эсэх нь баримтаар нотлогдохгүй байгаа бөгөөд төлөвлөлтийн талаар судалгаа шинжилгээ хийсэн баримт материал байхгүй байна.

Төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний ажлуудын хэлэлцэх баг, иргэдийн нийтийн хуралд та оролцож байсан уу?



Улс, орон нутгийн төсвөөр хийгдэх төсөл, арга хэмжээнүүдийг иргэдээр хэлэлцүүлж саналыг авдаг эсэх талаар судалгаа авахад судалгаанд оролцсон аймгийн 7 сумын 119 иргэний 64,0% нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын талаар мэдээлэлгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.5.5 дахь "хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх" гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

А.2. Зураг, төсөв хийгдээгүй төсөл арга хэмжээ батлагдсаар байна.

1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад нэр, байршил тодорхой, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулагдсан, магадлал хийгдсэн, зохих зөвшөөрлүүд олгогдсон төсөл арга хэмжээнүүд Төсвийн тухай хууль болон Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу тусгагдан батлагддаг байна.

Төсөл, арга хэмжээний мөнгөн дүнд өөрчлөлт орж батлагдсанаас болж зураг, төсвийг дахин хийлгэх тохиолдлууд гарч байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

Дорнод аймгийн хэмжээнд 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 18 ТАХ хэрэгжихээр батлагдсанаас зураг төсөв шаардлагатай 13 ТАХ-ний зураг, төсөв нь төсөв батлагдсанаас хойш буюу тайлант хугацаанд хийгдсэн байна.

№	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/
1	"Эрүүл мэндийн төвийн халаалтын тогооны засвар" /Гурванзагал сум/	22,330
2	Эрүүл мэндийн төвийн засвар /Баяндун сум/	53,550
3	8 дугаар сургуулийн халаалтын системийн засвар /Хэрлэн сум/	26,600
4	Сургуулийн барилгын гадна дулааны шугам засвар өргөтгөл /Хэрлэн сум 11 дүгээр сургууль/	47,491
5	Сургуулийн дотуур байрны засвар /Цагаан-Овоо сум/	24,872

6	Сургуулийн барилгын дээврийн засвар /Халхгол сум/	116,106
7	Сургуулийн барилгын халаалтын тогооны засвар /Халхгол сумын Ялалт баг/	13,667
8	10 дугаар цэцэрлэгийн барилгын засвар /Хэрлэн сум/	56,999
9	14 дүгээр цэцэрлэгийн барилгын дээвэр засвар /Хэрлэн сум/	60,000
10	Цэцэрлэгийн дээврийн засварын ажил гүйцэтгэх гэрээ /Чулуунхороот сум/	60,000
11	Барилгын цахилгаан, сантехникийн засвар /Хэрлэн сум, Биеийн тамир, спортын газар/	15,000
12	Биеийн тамир, спортын газрын зоорийн давхарын тохижилтийн засварын ажил /Хэрлэн сум, Биеийн тамир, спортын газар/	15,100
13	Матад Чойбалсан сумын эрүүл мэндийн төв, Баян-Уул сумын сум дундын эмнэлэгийн халаалтын тогооны их засварын ажил	76,685
13	Дүн	588,400

ТАХ-ний зураг, төсвийг боловсруулан хүргүүлсэн нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Зураг, төсөвгүй, магадлал хийгдээгүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг баталж улмаар уг төсөвтөө багтаан зураг, төсөв, техникийн тодорхойлолтыг дахин шинэчлэн гаргадаг зөрчил арилаагүй байна.

Зүүн бүсийн ахмад настны асрамжийн төвийн шинэ барилгад газар болон техникийн нөхцөл нь төсөв батлагдсанаас хойш хийгдсэн мөн зураг, төсөвт нь магадлал хийгдээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 32 ТАХ төлөвлөгдсөнөөс зураг, төсөв шаардлагатай 2 ТАХ-ний зураг, төсөв мөн л төсөв батлагдсанаас хойш хийгдсэн байна.

№	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/
1	Орон сууцны барилгуудын дээврийн засвар /Халхгол сум/	41,300
2	Чойбалсан хотын орон сууцны барилгуудын дээврийн засвар /Хэрлэн сум/	270,400
2	Дүн	311,700

Энэ нь Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2. "Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана." гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын II.7-д "Сумдад инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах" гэсэн ТАХ нь Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19 өдрийн 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.5.7.-д "аймаг, нийслэлийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгана:" гэсний 7.5.7.в-д "/ байршил;" гэснийг хангахгүй, байршил болон тоо тодорхойгүй байна.

А.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан эсэхийг санхүүжилт хангалттай төлөвлөгдөн батлагдсан байх, хөрөнгө оруулалтын болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хугацаандаа батлагдсан байх, төсвийн ерөнхийлөн захирагчдаас боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байдал гэсэн үзүүлэлтүүдээр авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд :

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Санхүүжилт дутуу төлөвлөгдөж, батлагдсанаас болж дараа он руу шилжсэн ТАХ байхгүй байна.
- Хөрөнгө оруулалтын болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө төсвийн тодотгол хийгдсэний дараа мөн адил өөрчлөгдөн батлагдсан байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчдаас 1,3,5,11 дүгээр саруудад эрх шилжүүлсэн ч уг ТАХ-нүүд бүгд тайлант хугацаанд амжилттай хэрэгжсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:


- Санхүүжилт дутуу төлөвлөгдөж, батлагдсанаас болж дараа он руу шилжсэн ТАХ байхгүй байна.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөлтөөс шалтгаалан төсөл арга хэмжээний хэрэгжилтэд асуудал үүсээгүй ч Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “ Орон нутгийн төсвийн төсөл боловруулах журам”ын 7.1.5.-д “худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.” гэсэн заалтыг хэрэгжүүлж орон нутгийн төсөвт хавсарган ИТХ-д оруулах шаардлагатай.
- Төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн хугацаанаас болж он дамжсан төсөл арга хэмжээ байхгүй байна.

II Бүлэг. Хариуцлагагүй байдлаас шалтгаалж чанаргүй, үр дүнгүй ажлууд хийгдсэн байна.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны 95.6 хувь нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан байна.

1. Дорнод аймгийн хэмжээнд 2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 18, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 32 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулсан байна.

Дүрслэл №3



Улсын төсвөөрх худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувьд 2 ажилд

харьцуулалтын аргаар тендер зохион байгуулсан ч оролцогч ирээгүй тул шууд худалдан авалт хийгдэх шийдвэр гарсан байна.

Орон нутгийн төсвөөрх ажлын хувьд үнэлгээний хороодыг зохих журмын дагуу байгуулж, тендерийн баримт бичгүүдийг хугацаанд нь боловсруулсан боловч Тендерийн хорооны зарим гишүүдийн АЗ сертификатын хугацаа дууссан, үнэлгээний хороонд ажиллахыг зөвшөөрсөн хуудсан дээр гарын үсэг зурагдаагүй зэрэг зөрчил байна. Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр дүгнэлтэд ТБОНӨХБАУХА тухай хуулийг зөрчсөн зүйл байхгүй байна.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 18 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг хуулийн дагуу захиалагч байгууллагын саналыг харгалзан зураг төсөв зохиох мэргэжлийн эрх бүхий байгууллагын тодорхойлсноор боловсруулсан эсэхийг үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- *Сургууль, эмнэлэгийн халаалтын тогооны хувьд Дорнод аймгийн орон нутгийн компани болох “Элтрүүд” ХХК нь элтрүүд ЧББ1-70 дулааны үүсгүүрийн ашигтай загварын гэрчилгээтэй тул бусад халаалтын тогооны засварын ажилд ТБОНӨХБАУХА тухай хуулийн 11.1.3 дахь “барааны нэр тэмдэг нэр хэлбэр маяг, төрөл гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага тавихгүй; мөн хуулийн 11.1.4. энэ хуулийн 11.1.3-т заасан шаардлага нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэж тодотгон заасны дагуу тус компаний халаалтын тогоог шалгуур болгосон байна.*
- *Эрүүл мэндийн газарт эрх нь шилжсэн Цагаан-Овоо, Булган, Чойбалсан, Халхгол, Баян-Уул сумын эмнэлэгт нийт төсөвт өртөг 9000.0 мян.төгрөгийн 5 мотоцикл нийлүүлэх ажлын даалгаварт ТБОНӨХБАУХА тухай хуулийн 11.1.3 дахь заалтыг зөрчин шууд хятад улсын “Dayun” ферм гэж заасан байна.*

Бусад худалдан авах ажиллагааны хувьд хуульд заасан шаардлагуудыг хангасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 32 төсөл арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулагдаагүй байна. Үүнд:

- *“Төрийн байгууллагын өзб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг сумдын нэгдсэн цахим хуудас хийх” нийт 12,000.0 мян.төг-ийн төсөвт өртөг бүхий ажил нь ТБОНӨХБАУХА тухай хуульд заасан шууд худалдан авах бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан байхад “Мэдээлэл технологийн чадамжийг хөгжүүлэх төв”, “Баамбалби” ХХК-иудтай шууд гэрээ байгуулсан байна.*

Орон нутгийн өмчийн газраас энэ талаар тодруулахад “АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албанаас тодруул” гэсэн тайлбар өгч, Олон нийттэй харилцах алба нь “Гүйцэтгэгчийг шалгаруулах явцад худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй байлгах нөхцлүүдийг авч хэрэгжүүлэн цахим хуудсанд /www.tender.gov.mn/ тендерийн урилгыг зарлан байршуулж, шаардлагатай тохиолдолд хуулийн дагуу шаардлага хангасан гурваас доошгүй этгээдэд урилга хүргүүлэн, хуулийн хугацаанд тендерийн холбогдох материалыг ирүүлээгүй тохиолдолд шууд худалдан авах шийдвэрийг үнэлгээний хорооны зүгээс төсвийг ерөнхийлөн захирагчид хүргүүлэх заалтын дагуу шууд гэрээ байгуулсан” гэсэн тайлбарыг өгсөн хэдий ч урилга нийтлүүлсэн, хүргүүлсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

Мөн шууд гэрээ байгуулсан гэх “Мэдээлэл технологийн чадамжийг хөгжүүлэх төв ” болон “Баамбалби” ХХК-тай “Тендерийн баримт бичиг”-т заасан гэрээний загвар, шаардлагад нийцээгүй гэрээг байгуулан санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.4 дэх “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.”, Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт,

санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.20 дахь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

ТЕЗ-ийн 2017 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж хуулийн хугацаанд тайлагнасан байна.

Б.2. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих зохиогчийн хяналтыг сайжруулж, зураг төсвийг боловсруулахдаа хэрэглэгчийн саналыг харгалзах шаардлагатай байна.


1. Хөрөнгө оруулалтын барилга байгууламжийн зураг, төслийг барилгын ажлын зохион байгуулалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, барилгын норм дүрмийн БНБД12-01-09, 12-03-04, БНБД12-04-06, БНБД12-1-1-05, БД12-106-14, БНБД12-01-09, БНБД2.01.01-93, БНБД41.01-0.2 стандартуудтай нийцүүлэн боловсруулсан байна.

Барилга байгууламжийн төсөвт өртгийн норм, үнийн зохистой хэмжээг

1. Ажиллах хүчний зардлыг хөдөлмөр зарцуулалтаар тооцож, МУ-ын БХБ-ын сайдын 2009 оны 09-р сарын 25-ны өдрийн №263 тоот тушаалаар “Зам барилгын ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг үнэ”
2. Барилгын төсвийг ЗТБХБС-ын 181 тушаалаар батлагдсан “Төсөв зохиох дүрэм”/БНБД 81-95-12/
3. Тээврийн тооцоог ЗТАЖЯ-ны сайдын №136 тоот тушаалаар
4. Барилгын материалын үнийг “Барилгын материал, бүтээц, эдлэлийн үнийн лавлах, түүнийг хэрэглэх заавар” БД 81-109-14
5. Машин механизмын ашиглалтын зардлыг “Барилгын машин ашиглалтын нэг машин цагийн жишиг үнэ тодорхойлох аргачлал” БД 81-111-11
6. Ган хоолой, насос зэрэг материалыг БД- 81-109-14
7. Гадаад болон бусад материалыг БД 81-109-14 гэсэн стандартуудын дагуу тооцсон байна.

2. Зураг, төсвийг стандартын дагуу тооцож, гүйцэтгэсэн ч анхаарах шаардлагатай дараах асуудлууд байна. Үүнд:

- “МЗА” компани зураг төсвийн дагуу чанартай сайн гүйцэтгэсэн боловч “Боомт орчмын дэд бүтцийг сайжруулах, тохижуулах” ажлын хүрээнд 50000,0 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий цахилгааны агаарын шугам нь ашиглагдаагүй байна. Учир нь хилийн бүсийн цэргийн анги тухайн агаарын шугамын хажууд байрладаг тул тухайн бүсэд үйл ажиллагаа эрхлэгч иргэд, хуулийн этгээд болон тухайн цэргийн ангийн хооронд үл ойлголцол үүссэнээс шалтгаалсан байна. Иймд анх зураг төсөв боловсруулахдаа тус газар нутгийн онцлог байдлыг харгалзан үзэх шаардлагатай байсан байна.
- 8-р сургуулийн халаалтын тогоог зураг төсвийн дагуу хийсэн гэх улсын комиссын дүгнэлт байгаа боловч ашиглалтыг үзэхэд нэмэлт насосыг ажиллуулахад узелийн өрөөнд халаалт төвлөрч шугам нь хэт халан бусад хэсгүүдийн дулаан буурч, насос ажиллуулахгүй тохиолдолд хэвийн халж байна. Энэ нь уг насос зураг төсөвт илүү тусгагдсаныг харуулж байна. Насосыг авахад нэмэлт зардал шаардагдахаар байна.
- Барилга байгууламжийн төсөвт өртгийг барилгын норм ба дүрэмд нийцүүлэн зохиосон боловч ижил төстэй халаалтын тогооны төсөвт өртгүүд ялгаатай байгаа нь /Гурванзагал - 23300.0 мян.төг, Баяндун - 57000.0 мян.төг, Ялалт баг -17000.0 мян.төг, Матад, Чойбалсан, Баян-Уул сумдад 3 халаалтын тогоо - 76685.0 мян.төг/ дотор холболтын ажлууд, буулгалт, насосын хүчин чадлын ялгаатай байдлаас үүдэлтэй байна. Үүнээс шалтгаалж халаалтын тогооны халаах хүчин чадал болон ашиглагчийн сэтгэл ханамж харилцан адилгүй байна. Зарим шинээр хийгдсэн халаалтын тогоо өмнөх жилүүдээс түлш идэлт нэмэгдсэн байна.



- Цэцэрлэг, сургуулийн барилгын дээврийн засварын ажлуудын хувьд Цагаан-Овоо сум Чулуун хороот сум, Хэрлэн сумын 10-р цэцэрлэгийн дээврийн засварын ажлууд зураг төсвийн дагуу сайн хийгдсэн, ашиглагч талын хувьд сэтгэл ханамж өндөр байна. Харин Халхгол сумын сургуулийн дээврийн засварын ажил хангалтгүй хийгдсэн, заалны дээврээс хана даган ус гоожсон байдалтай байна. Ашиглагч талаас анхны зураг төсөвт дээврийг шувуун нуруутай байхаар тусгавал насжилт удаан илүү тохиромжтой байх байсан гэсэн тайлбар өгсөн.
- 14-р цэцэрлэг, 10-р цэцэрлэг, Чулуунхороот сумдын дээврийн засварын ажлууд ижил, ойролцоо төсөвт өртөгтэй хийгдсэн бөгөөд 14-р цэцэрлэгийн хуучин бетон дээврийн хийцийг шувуун нуруун дээвэртэй болгох боломжгүй гэсэн тайлбарыг ГХБХБГ-ын мэргэжилтэн өгсөн.
- Чулуунхороот сумын цэцэрлэгийн /хуучин бетон, хар цаасан дээврийг хуулж, шинээр шувуун нуруун дээвэр хийсэн/ дээврийн талбай 10-р цэцэрлэгээс /хуучин шувуун дээврийг засаж, сольсон/ 1,4 дахин бага бөгөөд нэг метр квадрат төсөвт өртгийн зөрүү 7,5 мян төгрөгөөр их байна. Энэ нь тус сум аймгийн төвөөс 240 км зайтай, хуучин бетон дээврийг буулгах ажил зэрэг зардлууд нэмэгдсэн нь нөлөөлж байна. Дээрхээс дүгнэхэд сургууль цэцэрлэгийн дээврийн ажлыг төлөвлөхдөө шувуун нуруун дээвэртэй болгох нь зүйтэй байна.
- Жич:Төсөвт өртөг дэхь тээвэрлэлтийн зардал Чулуунхороот сум 5,363,226.0 төгрөг, 10-р цэцэрлэг 3,386,422.0 төгрөг буюу зөрүү 1,976,804.0 төгрөг, ажиллах хүчний зардал Чулуунхороот сум 9,132,209.0, 10-р цэцэрлэг 15,406,071 төгрөг буюу зөрүү 6,273,862.0 төгрөг байна.

Ямар байгууллага	Метр квадрат	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Нэгж Каватратын өртөг /мян.төг/	Тайлбар
Халх гол	11 163.0	125 000.0	116 106.0	10.4	Бетон дээвэр, хар цаас /Биеийн тамирын залнаас ус дуусан/
14-р цэцэрлэг	5 400.0	73 000.0	60 000.0	11.1	Бетон дээвэр, хар цаас /Ангиудуд хуучин ус дуусан/
10-р цэцэрлэг	2 736.0	72 000.0	60 000.0	21.9	Шувуун нуруу, төмөр листэн дээр /Ус дуусан зүйл байхгүй/
Чулуун хороот	2 042.2	72 000.0	60 000.0	29.4	Шувуун нуруу, төмөр листэн дээр /Ус дуусан зүйл байхгүй/

Ашиглагч талуудтай хийсэн ярилцлага, ажлын зураг авалтаас дүгнэхэд засварын ажлыг төлөвлөхдөө сургууль цэцэрлэгүүдийг шувуун нуруун дээвэртэй болгохоор тусгах нь зүйтэй байна.

Хэрлэн сумын орон сууцны дээврийн засварын ажлын хувьд чанартай сайн хийгдсэн хэдий ч дээвэр болон тааз 2-ын завсар хоорондын ажил зураг төсөвт тусгагдаагүй байдаг учир өвөл цан цохиж, дулаан орохоор дээд давхарын айлуудын

таазнаас ус шүүрдэг учир өмнө нь хийсэн засварын ажил үр дүнгүй болж байгааг анхаарах шаардлагатай байна.

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс 2017 онд зураг төсөвт өөрчлөлт орсон 1 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

Зүүн бүсийн ахмад настны асрамжийн газрын барилгын ажлыг “Ган-Октаэдр” компани хийсэн ба зураг төсөвт захиалагч талтай тохиролцсоны үндсэн дээр

- 1600x1600мм харьцаатай цонхыг 1500x1500мм харьцаатай болгох
- Дээврийн черепицийг гөлмөн төмрөөр солих
- Дээврийн дулаалгын хөөсөнцөр хавтанг үнсэн дулаалгаар солих
- Суурийн өндрийг 1450мм-ээс 1200мм болгож багасгах
- Узелийн өрөө болон ажилчдын хувцас солих өрөөний байршлыг солих
- Радиаторын оруулга болон буцах шугамын далд ажлыг ил болгох гэсэн өөрчлөлтүүдийг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байна.

Эдгээр өөрчлөлтөөс шалтгаалан төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна.

4. Барилгын тухай хуулийн 17 зүйл, 15 зүйл болон БНБД 11-04-99-т тус тус зааснаар захиалагч талаас зураг, төсөв зохиогчтой гэрээ байгуулахдаа давхар хяналт хийх гэрээ хийдэг ба гэрээний хэрэгжилтийг дүгнэхэд:

Зохиогч хяналтын гэрээг захиалагч талтай хийсэн боловч захиалагч, зохиогчийн хяналтын тайлан дутмаг, санхүүгийн гүйцэтгэлтэй уялдуулан хавсаргаагүй байгаа бөгөөд барилгын үе шатны улаан канттай дэвтэрт хавсаргаж явж байсан гэсэн тайлбарыг өгсөн. Аудитын явцад зураг төсвийн “ДОЗТ” ББН-ээс зохиогчийн хяналт хийсэн 11 дүгнэлт ирсэн.

Зохиогчийн хяналт хийсэн тайлан, дүгнэлтийг гүйцэтгэлийн баримтанд хавсаргаагүй зөрчил гарч байна.

Хяналтын дүнгээр өгсөн зөвлөмж, шаардлагын хэрэгжилт сайн хийгдсэн ч зарим нэг ажлууд улсын комисс хүлээж авсны дараа хийгдээгүй байгаа нь ашиглагч болон гүйцэтгэгч, захиалагч талын хоорондын уялдаа холбоо муу байгааг харуулж байна.

Б.3. Гүйцэтгэгч компаниуд гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй тохиолдлууд гарсан байна.

1. Гүйцэтгэгч талын баримтын дутуу бүрдүүлэлт, зөрүүтэй мэдээлэл, захиалагч талын хяналтгүй байдлуудаас үүдэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа компанийн ажиллах хүчний чадавх, техник, тоног төхөөрөмжийг хангалттай үнэлэлгүй шалгаруулж, ажлын явцад хяналт бүрэн тавихгүй байгаа нь чанаргүй ажил хийгдэх, үргүй зардал гарах нөхцөлийг бий болгож байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд нийт 19 төсөл, арга хэмжээ (шилжих 1, шинээр 18) хэрэгжсэнээс ажиллах хүчин, техник, тоног төхөөрөмж шаардагдах 14, шаардлагагүй 5 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр 14 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчдээс ажиллах хүч, техник хэрэгслээр бүрэн хангагдсан 11, бүрэн хангагдаагүй 3 компани байсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12 дугаар зүйл¹-д заасан шаардлагад нийцэхгүй байна. Тухайлбал:

Ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй:

- Барилгын цахилгаан, сантехникийн засвар /Хэрлэн сум, БТСГ/-ыг гүйцэтгэсэн “Дорнын гэрэлт цамхаг” ХХК – НДШ төлдөг 1 ажилтан, 29,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байгаа нь ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй.

¹ Тендерт оролцогчийн чадварыг үнэлэх

- Сургуулийн барилгын гадна дулааны шугам засвар /Хэрлэн сум, 11-р сургууль/-ыг гүйцэтгэсэн “Дорсүхэ” ХХК – 17 ажилтантай гэх боловч НДШ төлдөг 2 ажилтан, санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөө тусгагдаагүй.
- Сургуулийн барилгын халаалтын тогооны засвар /Халхгол сум, Ялалт баг/-ыг гүйцэтгэсэн “Бүжнэр” ХХК - Татвар төлдөг 13 ажилтан, 137,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй гэх боловч энэ ажлыг гүйцэтгэхдээ компанийн бус гадны гэрээт ажилтнуудаар гүйцэтгүүлсэн.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд нийт 39 төсөл, арга хэмжээ (шинээр хэрэгжүүлэх 28, шилжих 7, авто замын сангаар 4) хэрэгжсэнээс ажиллах хүч, техник, тоног төхөөрөмж шаардагдах 22 (барилгын засвар, халаалтын тогоо, шугамын засварын ажилд), шаардлагагүй 17 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр 22 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчдээс ажиллах хүч, техник хэрэгслээр бүрэн хангагдсан 17 компани, ажиллах хүчээр бүрэн хангагдаагүй 5 компани байна. Тухайлбал:

Ажиллах хүчин, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй:

- Сургуулийн барилгын гадна дулааны шугам засвар /Хэрлэн сум, 11-р сургууль/-ыг гүйцэтгэсэн “ДОРСҮХЭ” ХХК – НДШ төлдөг 2 ажилтантай, компанид бүртгэлтэй үндсэн хөрөнгөөгүй,
- Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдах хатуу хучилттай авто замын трассыг сэргээн тодотгох, тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгэсэн “Дорнын Транзит” ХХК – НДШ төлдөггүй, орон нутагт бүртгэлгүй,
- Аймгийн залуучуудын нэгдсэн мэдээллийн сайт хийх /ГБХЗХГазар/ ажлыг гүйцэтгэсэн “Дорнын хийц пресс” ХХК – НДШ төлдөггүй, орон нутагт бүртгэлгүй,
- Төрийн байгууллагуудын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг, сумдын нэгдсэн цахим хуудас хийх ажлыг гүйцэтгэсэн “Мэдээлэл технологийн чадамжийг дээшлүүлэх төв”, “БААМБАЛБИ” ХХК - Орон нутагт бүртгэлгүй, НДШ төлдөггүй,
- Сумдад инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах /Баяндун, Баян-Уул, Хөлөнбуйр, Гурванзагал сум/ ажлыг гүйцэтгэсэн “Сатабу” ХХК - НДШ төлдөг 2 ажилтан, 143,9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байгаа нь ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй гэж үзэх үндэслэл болсон.

Аудитын явцад аймгийн ЗДТГ, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс авсан тоон мэдээлэлд тулгуурлан дээрх компаниудын ажиллах хүчин, техник, тоног төхөөрөмжийн байдалд үнэлэлт өгсөн болно.

2. Төсөл, арга хэмжээг зураг, төсвөөс зөрүүтэй хийсэн тохиолдол гараагүй байна. Харин зураг төсвийн дагуу боловч үр дүн муутай, ашиглалт багатай, ашиглалтгүй, гэрээний хугацаанаас хэтэрч гүйцэтгэсэн дараах ажлууд байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

- 8 дугаар сургуулийн халаалтын системийн засвар /Хэрлэн сум/ - Зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн боловч шахуургын насосыг бүрэн ашиглахгүй, цаг үеийн шинж чанартай ашиглаж байна. Мөн гэрээний хугацаанаас 10 хоног хэтэрч хүлээлгэж өгсөн.
- Эрүүл мэндийн төвийн засвар /Баяндун сум/ - Зураг нь “Элтрүүд” ХХК-ийн ашигтай загварын гэрчилгээний дагуу гэх боловч бодит байдал дээр үзэхэд БНХАУ-д үйлдвэрлэсэн тогоо тавьж, үзлэгийн өрөөнд магадлашгүй ажлын зардлаар шинээр насос тавьсан нь цахилгааны зардлыг нэмэгдүүлэх, үргүй зардал гаргах нөхцөлийг үүсгэж байна.
- Цагаан-Овоо, Булган, Чойбалсан, Халхгол, Баян-Уул сумын эмнэлгийн мотоцикл-Техникийн тодорхойлолтод заасантай тохирохгүй, ижил төстэй хүчин чадал бүхий мотоцикл байна.
- Сургуулийн барилгын халаалтын тогооны засвар /Халхгол сумын Ялалт баг/ - Чанаргүй, гэрээний хугацаанаас 10 хоног хэтэрч хүлээлгэж өгсөн.
- Зүүн бүсийн ахмад настны асрамжийн төвийн барилга - Гэрээний хугацаанаас 21 хоног хэтэрч /хэтэрсэн нийт хоног 51 хоног зөрүү 21 хоног/ хүлээлгэж өгсөн. Шалтгаан, нөхцөл нь аймгийн ЗД-тай гэрээ байгуулах хугацаа 30 хоногоор хойшлогдсоноос ажил нь хугацаандаа эхлээгүй байсан байна.
- Аймгийн ЗДТГ-ын барилга – Зураг төсөвт магадлалаар 2 удаа өөрчлөлт оруулж, ажил нь 2011 онд эхэлж, 2018.08.01-ний өдөр дуусгахаар төлөвлөж, ажлын гүйцэтгэл 85 хувьтай байгаа талаар аймгийн ГХБХБГ-аас дүгнэсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:**Ажлын гүйцэтгэл дутуу:**

- Төрийн байгууллагуудын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг, сумдын нэгдсэн цахим хуудас хийх ажлыг гүйцэтгэсэн “Мэдээлэл технологийн чадамжийг дээшлүүлэх төв”, “БААМБАЛБИ” ХХК – Хэрлэн сумын цахим хуудсыг хүлээлгэж өгөөгүй, 14 сумдын цахим хуудасны ажлын гүйцэтгэл 50 хувь, ашиглалт 33 хувьтай, сайтын бүтэц, мэдээллийн агуулга чанарын шаардлага хангахгүй байна.
- Дорнод аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг хүлээж авсан боловч, бодит байдал дээр гүйцэтгэл 90 хувь, эцсийн байдлаар боловсруулагдаж, ИТХ-аар батлуулах ажил дуусаагүй байна.

Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй:

- Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдах хатуу хучилттай авто замын трассыг сэргээн тодотгох, тэмдэгжүүлэх ажил 10,0 сая, “Дорнын Транзит” ХХК – Зураг, төсөв хийгдээгүй, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэсэн байна. Тэмдэгжүүлэлт хийгдэнэ гэж баталсан боловч, ажлын даалгаварт тусгагдаагүй. Гэрээний хугацаанаас 86 хоног хоцроосон.
- Чойбалсан хотын авто замын засвар, арчлалт, тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч тавих ажил 40,0 сая, “Авто агро” ХХК, “Хан шонуу” ХХК – “Авто агро” ХХК 16,2 сая төгрөгийн өртөгтэй замын засвар, арчлалт, хурд сааруулагч тавих ажлыг гэрээний хугацаанаас 29 хоногоор хоцроосон, “Дорнын Транзит” ХХК-ийн нийлүүлсэн 23,2 сая төгрөгийн өртөгтэй төхөөрөмж нь ашиглалтгүй байна.
- “Шүр” захын хойно улаан бойлер орчмын цэвэр усны шугам хоолойг засварлах материал, техник машин механизмын зардалд /Хэрлэн сум 6-р баг/ 19,6 сая, “Дорсүхэ” ХХК – Бараа, материалыг гэрээний хугацаанаас 64 хоногоор /нийт хоцроосон хугацаа 94 хоног, 30 хоногт алданги тооцсон/ хоцроож нийлүүлсэн.
- Хурал, зөвлөгөөний танхимын тохижилт /АЗДТГ/ 25,0 сая, “Ханшонуу” ХХК – Гэрээний хугацаанаас 3 хоногоор хоцроож, бараа материал нийлүүлсэн.
- Содномдаржаагийн гудамжнаас Хивс, Ялалтын гудамж дундуур шинээр хатуу хучилттай авто зам тавих, явган зам, гэрэлтүүлгийн хамт /Хэрлэн сум, 10-р баг/ - Гэрээний хугацаанаас 29 хоногоор хоцроосон.

3. Аудитын явцад төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгах зорилгоор зарим компаниудын төлөөллүүдийг дуудаж уулзах, холбогдох тайлбар, баримт, материал /гүйцэтгэлийн баримт/-ыг үзэх ажилбарууд хийгдсэн бөгөөд гүйцэтгэгч компаниудаас (“Бүжнар” ХХК, “МЗА” ХХК, “Сатабу” ХХК) бараа, материалын гарал үүслийн гэрчилгээ, гаалийн татвар төлсөн баримт, санхүүгийн анхан шатны баримт зэргийг авчруулахыг шаардсан боловч өнөөдрийг хүртэл баримтаа ирүүлэхгүй, гаргаж өгөхгүй байгаа нь аудитад хүндрэл учруулж үр дүнг бүрэн тодорхойлох боломжгүй болгож байна. Мөн захиалагчийн хяналтын тайланд бараа материалын гарал үүслийн гэрчилгээ, материалын чанарт хийсэн үнэлгээ зэрэг ажлууд байхгүй байгаа нь чанаргүй ажил хийгдэх эрсдэлийг бий болгосон байна.

“Дорнын гэрэлт цамхаг” ХХК-ийн гүйцэтгэсэн нийт 30,1 сая төгрөгийн өртөгтэй (15,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Биеийн тамир, спортын газрын зоорийн давхрын тохижилтын засварын ажил, 15,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цахилгаан, сантехникийн засварын ажил) улсын төсвөөс санхүүжсэн засварын ажлуудыг гүйцэтгэхэд зарцуулсан санхүүгийн баримтуудыг ирүүлсэн. Анхан шатны баримтаас үзэхэд санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Б.4. Захиалагч гэрээний хэрэгжилтэд хяналтыг бүрэн тавьж ажиллаагүй байна.

1. Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл арга хэмжээнүүдийн гэрээний нөхцөлүүд байхгүй, стандартын бус гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАУХАТХ-

ийн 19.1², 40.3³ дахь заалтуудад нийцэхгүй байна. Энэ нь ажлын үр дүнг тооцоход хүндрэл учруулж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Сургуулийн барилгын халаалтын тогооны засвар /Халхгол сум, Ялалт баг/ - (“Бүжнар” ХХК) – Гэрээнд үүрэг хариуцлагыг бүрэн тусгаагүй, стандартын бус гэрээ байгуулсан байна.
- Барилгын цахилгаан, сантехникийн засвар /Хэрлэн сум, БТСГ/ - (“Дорнын гэрэлт цамхаг” ХХК) – Гэрээнд үүрэг, хариуцлагыг бүрэн тусгаагүй.
- Биеийн тамир, спортын газрын зоорийн давхрын тохижилтын засварын ажил /Хэрлэн сум, Биеийн тамир, спортын газар/ - (“Дорнын гэрэлт цамхаг” ХХК) – Гэрээнд үүрэг, хариуцлагыг бүрэн тусгаагүй.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Дорнод аймгийн аялал жуучлалын мастер төлөвлөгөө боловсруулах /БОАЖГ/ 35,0 сая,
- Дорнод аймгийн төрийн байгууллагуудын ажлын гүйцэтгэл, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах цогц программ 50,0 сая,
- “Эйбл софт” ХХК, аймгийн залуучуудын нэгдсэн мэдээллийн сайт хийх /ГБХЗХГазар/ 10,0 сая,
- Төрийн байгууллагуудын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг, сумдын нэгдсэн цахим хуудас хийх 12,0 сая, “Мэдээллийн технологийн чадамжийг дээшлүүлэх үндэсний төв”, “БААМБАЛБИ” ХХК,
- Татвар төлөгчдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх, татварын тайланг цахимаар хүлээн авах ажлын хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж /Татварын хэлтэс, сумдын ЗДТГ/ 50,0 сая, “Ган тэлмэн” ХХК,
- “Нэг цонхны үйлчилгээ”-ний цэгт, шаардлагатай тоног төхөөрөмж /Улсын бүртгэлийн хэлтэс/ 5,7 сая, “Некст электроникс” ХХК,
- Бэлэн бус торгуулийн машин худалдан авах /Цагдаагийн газар/ 7,5 сая, “Аи Си Ай Систем Монголия” ХХК,
- Хог тээврийн автомашинд, ачих төхөөрөмж суурилуулах /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ 20,0 сая, “Дорнын Транзит” ХХК,
- Явган замын хавтан үйлдвэрлэх тоног төхөөрөмж /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ 10,0 сая, “Талын ат” ХХК,
- Цас, шороо шүүрдэх төхөөрөмж /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ 20,0 сая, “Хан шонуу” ХХК,
- Зөөврийн ариун цэврийн байгууламж /Хэрлэн сум/ 30,0 сая, “Дорнын Транзит” ХХК

2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавьсан захиалагчийн үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй дараах ажил байна. Үүнд:

- Барилгын цахилгаан, сантехникийн засвар /Хэрлэн сум, Биеийн тамир, спортын газар/ - Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх аймгийн ЗДТГ хяналт тавьж ажиллаагүй, тухайн ажлыг улсын комисс хүлээж авсан байна.

Захиалагчийн хяналт үр дүнгүй хийгдсэн дараах ажил байна. Үүнд:

- Сургуулийн барилгын халаалтын тогооны засвар /Халхгол сум, Ялалт баг/ - (“Бүжнар” ХХК) - Захиалагчийн хяналтаар өгсөн үүрэг бүрэн хэрэгжээгүй, фото зургаар хүлээлгэж өгсөн. Ангиудын доторх дулааны шугамнаас ус шүүрсэн хэвээр байгаа нь үргүй зардал гарах нөхцөл үүсгэж байна.

² 19.1.Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ.

³ - 40.3.Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана:

40.3.1.гэрээний үнэ; 40.3.2.төлбөр хийх нөхцөл, хэлбэр; 40.3.3.урьдчилгаа төлбөр хийх бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, хэлбэр; 40.3.4.захиалагчийн хяналт болон бусад нөхцөл; 40.3.5.гүйцэтгэлийн баталгаа шаардах бол түүний дүн, хэлбэр; 40.3.6.худалдааны нөхцөлүүд; 40.3.7.бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь; 40.3.8.гэрээний үнэд тохируулга хийх бол тохируулга хийх нөхцөл, аргачлал.

- 14 дүгээр цэцэрлэгийн барилгын дээвэр засвар /Хэрлэн сум/ - (“Бүжнар” ХХК) - Гүйцэтгэх явцад ангиудын таазнаас борооны ус гоожсоны улмаас 1 ангийн хяналтын камер эвдэрч, ажиллагаагүй болсныг одоог хүртэл засварлаагүй байгаа нь анги, танхимын хадгалалт, хамгаалалт, хүүхдийн хүмүүжилд тавих хяналтын системийг үр дүнгүй болгож байна. Иймд камерыг яаралтай ажиллагаанд оруулах, гүйцэтгэгч компанийн хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй дараах ажил байна. Үүнд:

- Аймгийн залуучуудын нэгдсэн мэдээллийн сайт хийх /ГБХЗХГазар/ 10,0 сая, “Дорнын хийц пресс” ХХК
- Төрийн байгууллагуудын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг, сумдын нэгдсэн цахим хуудас хийх 12,0 сая, “Мэдээллийн технологийн чадамжийг дээшлүүлэх үндэсний төв”, “БААМБАЛБИ” ХХК – Гүйцэтгэл 50 хувь, ашиглалт 33 хувьтай байгаа нь үр дүнгүй ажил болсон байна.

Ашиглалт багатай, үр дүнгүй ажлууд:

- Хог тээврийн автомашинд, ачих төхөөрөмж суурилуулах /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ 20,0 сая, “Дорнын Транзит” ХХК - ашиглалтгүй
- Явган замын хавтан үйлдвэрлэх тоног төхөөрөмж /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ 10,0 сая - ашиглалтгүй
- Цас, шороо шүүрдэх төхөөрөмж /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ 20,0 сая, “Ханшонуу” ХХК - ашиглалтгүй
- “Нэг цонхны үйлчилгээ”-ний цэгт шаардлагатай тоног төхөөрөмж /Улсын бүртгэлийн хэлтэс/ 5,7 сая, “Некст электроникс” ХХК – зориулалт бусаар ашиглаж байгаа

3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтийг баталгаажуулахдаа хугацаа хэтэрсэн ажлуудад алданги тооцоогүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1 ТАХ-ний гүйцэтгэлд хариуцлага тооцож, 3 ТАХ-ний гүйцэтгэлд ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 3.7⁴ дахь заалтыг зөрчиж гэрээний үүргээ биелүүлэлгүй хугацаа хэтэрсэн ажилд гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна. Үүнд:

Тодорхой шалтгааны улмаас гэрээний хугацаанаас хэтэрч дууссан ажлууд:

- Сургуулийн барилгын халаалтын систем засвар /Дорнод, Хэрлэн сум, 8 дугаар сургууль/, - Гэрээ нь 26,6 сая төгрөг, “Бүжнар” ХХК 10 хоног хэтэрсэн.
- Сургуулийн барилгын халаалтын тогооны засвар /Дорнод, Халхгол сум, Ялалт багийн сургууль/ - Гэрээ нь 13,7 сая төгрөг, “Бүжнар” 10 хоног хэтэрсэн.
- Зүүн бүсийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн өргөтгөл, засвар - Гэрээ нь 287,0 сая төгрөг, “Ган октаэдр” ХХК 21 хоног хэтэрсэн.
- Сургуулийн барилгын дээврийн засвар /Халхгол сум/ - Гэрээ нь 116,1 сая төгрөг, “ЦОДММ” ХХК 43 хоног хэтэрсэн нь өмнөх санхүүжилтээ аваагүй, цаг агаарын нөхцөл, давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой байна.

Он дамжин хэрэгжиж байгаа ажил:

- Аймгийн ЗДТГ-ын барилга 6,5 тэрбум төгрөг, “Ган хийц” ХХК. Анх 2011 онд ажил эхэлж, зураг төсөвт магадлалаар 2 удаа өөрчлөлт оруулсан. Гэрээний хугацаа сунгаагдаж, 2018 оны 08 дугаар сард ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна.

Хариуцлага тооцсон ажил:

- Халаалтын тогооны засвар /Дорнод аймаг Гурванзагал/ - Гэрээ нь 22,3 сая төгрөг, “Элтрүүд” ХХК 4 хоног хэтэрсэнд 44,6 мянган төгрөгийн алдангийг суутгасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 4 ТАХ-ний

⁴ 3.7. Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана.

гүйцэтгэлд хариуцлага тооцоогүй байна. Тухайлбал,

Тодорхой шалтгааны улмаас гэрээний хугацаанаас хэтэрч дууссан ажлууд:

- Чойбалсан хотын авто замын засвар, арчлалт, тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч тавих - Гэрээ нь 16,8 сая төгрөг, “Авто агро” ХХК 12 хоног хэтэрсэн.
- Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдах хатуу хучилттай авто замын трассыг сэргээн тодотгох, тэмдэгжүүлэх - Гэрээ нь 10,0 сая төгрөг, “Дорнын Транзит” ХХК 86 хоног хэтэрсэн.
- Хурал, зөвлөгөөний танхимын тохижилт /АЗДТГ/ - Гэрээ нь 25,0 сая төгрөг, “Хан шонуу” ХХК 3 хоног хэтэрсэн.
- Содномдаржаагийн гудамжнаас Хивс, Ялалтын гудамж дундуур шинээр хатуу хучилттай авто зам тавих, явган зам, гэрэлтүүлгийн хамт /Хэрлэн сум, 10-р баг/ - Гэрээ нь 150,0 сая төгрөг, “Авто агро” ХХК 8 хоног хэтэрсэн.
- “Шүр” захын хойно улаан бойлер орчмын цэвэр усны шугам хоолойг засварлах материал, техник машин механизмын зардалд /Хэрлэн сум 6-р баг/ 19,6 сая төгрөг, “Дорсүхэ” ХХК – Ажил гүйцэтгэх байсныг бараа, материал нийлүүлэх болгон өөрчилснөөс хугацаа 60 хоногоор хойшилсон байна.
- Орон сууцны барилгуудын дээврийн засвар /Халхгол сум/ 41,3 сая, “Донж өргөө” ХХК – Гэрээний хугацаанаас 30 хоногоор хойшилсон нь цаг агаарын давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан байна.

Он дамжин хэрэгжиж байгаа болон хугацаа нь тодорхойгүй ажил:

- Дорнод аймгийн аялал жуучлалын мастер төлөвлөгөө боловсруулах /БОАЖГ/ 35,0 сая – Ажил нь бүрэн гүйцэд дуусаагүй, гүйцэтгэл 90 хувь байхад хүлээж авсан. /Санхүүжилтийг нь бүрэн өгсөн/
- Дорнод аймгийн төрийн байгууллагуудын ажлын гүйцэтгэл, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах цогц програм 50,0 сая, “Эйбл софт” ХХК – Ажил нь бүрэн дуусаж, хүлээлгэж өгөөгүй. /Санхүүжилтийг нь бүрэн өгсөн/

Гүйцэтгэл бүрэн дуусаагүй байхад хүлээж авсан ажил:

- Төрийн байгууллагуудын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг, сумдын нэгдсэн цахим хуудас хийх 12,0 сая, “Мэдээллийн технологийн чадамжийг дээшлүүлэх үндэсний төв”, “БААМБАЛБИ” ХХК - 14 сумдын цахим хуудасны ажлын гүйцэтгэл 50 хувь, ашиглалт 33 хувьтай, сайтын бүтэц, мэдээллийн агуулга чанарын шаардлага хангахгүй байна.

4. ТАХ-ний санхүүжилтийг олгохдоо Төсвийн тухай хуулийн 41.2.6⁵, “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.5⁶-д заасан нөхцөл, шаардлагын дагуу худалдан авах ажиллагааны үр дүнгийн биелэлтийг холбогдох цахим систем /tender.gov.mn/-д оруулсныг нотлох мэдээлэл, ТЭЗҮ, зураг төсөв, техник, хяналт, зөвлөх үйлчилгээний гэрээ зэрэг бүрдүүлбэрийг ажлын гүйцэтгэлийн баримтад хавсаргаагүй байхад санхүүжилтийг олгосон нийтлэг зөрчил гарч байна.

Гүйцэтгэл нь 2011 оноос эхэлсэн аймгийн ЗДТГ-ын барилгын ажилд 2017 онд нийт 932,5 сая төгрөгийн санхүүжилт олгогдохоор тусгагдсанаас, 802,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 130,5 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлэлгүй аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд авч үлдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 43.1⁷ дэх заалтад нийцэхгүй байна.

⁵ -Төсвийн тухай хууль 41.2.6. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх

⁶ “Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн хянаж баталгаажуулсан гарын үсэг бүхий албан тоот, холбогдох материалыг энэхүү журмын хоёр болон гуравдугаар хавсралтаар батлагдсан “Хяналтын хүснэгт”-д тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг дараах материалыг үндэслэн ажлын 2 хоногийн дотор санхүүжүүлнэ.”

⁷ Төсвийн тухай хуулийн 43.1.Тухайн төсвийн жилд ашиглагдаагүй төсвийн дараах үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулж болно:

43.1.1.Засгийн газрын өрийн бичиг, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр;

43.1.3.Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөв;

43.1.5.төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан тусламж, хандив.

5. Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6.2⁸, 6.2⁹, 6.3¹⁰ дахь заалтуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаарх тайлан, мэдээг сар бүр Сангийн яаманд хүргүүлэхээр заажээ. Уг заалтыг хэрэгжилтийг шалгахад аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн холбогдох мэргэжилтнүүд нь тайлан, мэдээг хүргүүлдэггүй байна.

6. Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд хийгдсэн нийт ТАХ-ний 11 ажлын зураг, төсвийг “ДОЗТ” ХХК, 1 ажлын зураг, төсвийг “Альфа поинт” ХХК гүйцэтгэсэн байна. “ДОЗТ” ХХК-ийн гүйцэтгэсэн 2 ТАХ-ний зураг, төсвийг хүлээж авахдаа ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 3.7¹¹ дахь заалтыг баримтлахгүй гэрээний хугацаанаас хоцроож хүлээж авсан нь захиалагч талын хяналтын үр нөлөөг бууруулж байна.

Захиалагч талын тайлбар: “ДОЗТ” ХХК-ийн хувьд 2017 онд олон ажлын зураг, төсвийг зэрэг эхлүүлсэн учраас 2 ажлыг гэрээний хугацаанаас хоцроох асуудал гарсан. Ачааллыг харгалзан үзэж, гүйцэтгэгчид хариуцлага тооцож ажиллаагүй. Алданги тооцъё гэхээр эрх нь манай байгууллагад байдаггүй. Өмнө нь 2016 онд зураг төсвийг хугацаа хоцроож хийсэн “ИГ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг сунгахгүй байх хүртэл арга хэмжээ авч ажилласан. Өнгөрсөн жилийн хувьд зураг төсвийн нэг л компани байсан учраас хариуцлага тооцоогүй. Энэ жилийн хувьд зураг төсвийн компаниуд шинээр нэмэгдсэн.” гэсэн хариултыг аудитын явцад аймгийн ГХБХБГ-аас өглөө.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хийгдсэн нийт ТАХ-ний 5 ажлын зураг, төсвийг “ДОЗТ” ХХК, 1 ажлын зураг, төсвийг “Хайрт бүрд” ХХК гүйцэтгэсэн байна. Үүнээс “ДОЗТ” ХХК-ийн гүйцэтгэсэн 1 ТАХ-ний зураг, төсвийг хугацаа хоцроож хүлээж авсан байна.

Захиалагч талын тайлбар: “ДОЗТ” ХХК-ийн хувьд 2017 онд олон ажлын зураг, төсвийг зэрэг эхлүүлсэн учраас 1 ажлыг гэрээний хугацаанаас хоцроох асуудал гарсан. Ачааллыг харгалзан үзэж, гүйцэтгэгчид хариуцлага тооцож ажиллаагүй. Алданги тооцъё гэхээр эрх нь манай байгууллагад байдаггүй. Өмнө нь 2016 онд зураг төсвийг хугацаа хоцроож хийсэн “ИГ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг сунгахгүй байх хүртэл арга хэмжээ авч ажилласан. Өнгөрсөн жилийн хувьд зураг төсвийн нэг л компани байсан учраас хариуцлага тооцоогүй. Энэ жилийн хувьд зураг төсвийн компаниуд шинээр нэмэгдсэн.” гэсэн хариултыг аудитын явцад аймгийн ГХБХБГ-аас өглөө.

Б.5. Аймгийн ЗДТГ нь санхүүжилтийг олгохдоо СС-ын 2016 оны 415-р журмыг баримтлахгүй байна.

1. Аудитын явцад төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх журмын эрх зүйн орчинг шинэчлэх шаардлага байгаа эсэх талаар холбогдох мэргэжилтэн, аж ахуйн нэгжүүдийн төлөөллүүдээс санал авахад анхаарах шаардлагатай дараах зүйлүүд байна. Тухайлбал:

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалтай холбоотой санал:

- “Санхүүжилтийг хуваарийн дагуу бус, 2-3 сараар хойшилж авдаг. Гэрээний хугацаанаас хоцорсон ажилд биднээс алданги тооцож авдаг. Харин санхүүжилтээ хоцроохдоо бидэнд алданги төлдөггүй. Эдгээрийг бодит байдал дээр нийцүүлэх шаардлагатай.” гэж ярилцлагад хамрагдагсад, ААН-ийн төлөөллийн 60-аас дээш хувь нь илэрхийлсэн.

⁸ 6.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн тайланг сарын бүрийн 5-ны дотор

⁹ 6.3. ТЭЗ-ийн багцад батлагдсан боловч ХАА нь орон нутагт эрх шилжиж буй ХО-ын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүрийн 3-ны дотор

¹⁰ 6.3. Ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг 4-р сарын 10-ны дотор СЯ-нд хүргүүлнэ.

¹¹ 3.7. Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана.

ТБОНӨХБАУХАТ хуулийн зарим заалтад нэмэлт өөрчлөлт оруулах талаар:

- “Хамгийн сайн тендерийг шалгаруулахдаа бага үнийн санал гэхээсээ илүү тухайн компанийн өмнөх ажлын туршлага, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн байдлыг харгалзан үздэг байх.” гэсэн санал, хүсэлтийг ярилцлагад оролцогсдын 75 хувь нь өгсөн.

2. Гүйцэтгэгчид санхүүжилтийг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.5¹² дахь 11 бүрдүүлбэрийг үндэслэн олгохоор заасан.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд нь “дээрх журмыг бус Төсвийн тухай хуулийн холбогдох заалт, ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тогтоол, “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг үндэслэдэг” гэсэн тайлбарыг өгсөн бөгөөд журамд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг бүрэн хянадаггүй, санхүүжилтийг хуваарьт заасан хугацаанаас хоцроон олгодог зөрчил ажиглагдлаа.

III бүлэг. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

В.1. Хөрөнгө оруулалтын 2017 оны зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд баталсан 18 төсөл, арга хэмжээг зориулалтаар ангилбал: Эрүүл мэнд, нийгмийн халамжийн 39,0%, Боловсролын салбар 56,0%, бусад салбарт 5,0% тус тус зориулагдсан байна.

Эдгээрээс төлөвлөсөн зорилтот түвшин бүрэн хангагдаагүй, ашиглагдахгүй байгаа ажлууд байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

1.Зүүн бүсийн ахмад настны асрамжийн төв /320,0 сая төгрөг/

2.Цагаан-Овоо, Булган, Чойбалсан, Халхгол, Баян-Уул сумын эмнэлэгт мотоцикл /9,0 сая төгрөг/

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:


Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд нийт 32 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжсэн боловч зорилтод түвшин бүрэн хангагдаагүй, огт ашиглагдахгүй дараах ажлууд байна.Үүнд:

¹² СС-ын 2016 оны 415 дугаар тушаал 4.5. Шаардлага, шалгууруудыг хангаж байгаа эсэхийг дараах материалыг үндэслэн ажлын 2 хоногийн дотор санхүүжүүлнэ. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай албан тоот, үнэлгээний дүгнэлт, Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл
- Захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээний эх хувь /Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Гэрээний маягт”-ын дагуу гэрээ байгуулна./
- Худалдан авах ажиллагааны үр дүнгийн биелэлтийг холбогдох цахим систем /tender.gov.mn/-д оруулсныг нотлох мэдээлэл
- Тендерт шалгарч гэрээ байгуулсан этгээдийн барилга угсралт, их засварын ажлын төлөвлөгөө, түүнийг төсөвт өртөгт эзлэх дүнгээр тодорхойлсон барилгын санхүүжилтийн хуваарь /энэ журмын тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргана./
- Гүйцэтгэлийн баталгаа /Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн баталгааны маягт”-ын дагуу гаргана./
- Урьдчилгаа төлбөрийн баталгаа /Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт”-ын дагуу гаргана./
- Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл /энэ журмын дөрөв, тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргана./
- Барилга, байгууламж, засварын ажил, тоног төхөөрөмжийн гэрэл зураг
- ТЭЗҮ, зураг төсөв, техник, хяналт, зөвлөх үйлчилгээний гэрээ
- Барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт
- Төсвийн шууд захирагчийн хянан баталгаажуулсан албан тоот


1. Хог тээврийн автомашинд, ачих төхөөрөмж суурилуулах /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ /20,0 сая төгрөг/
2. Цас, шороо шүүрдэх төхөөрөмж /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/ /20,0 сая төгрөг/
3. Дорнод аймгийн аялал жуучлалын мастер төлөвлөгөө боловсруулах /БОАЖГ/ /35,0 сая төгрөг/
4. Боомт орчмын дэд бүтцийг сайжруулах, тохижуулах/50,0 сая төгрөг/
5. Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг сумдын нэгдсэн цахим хуудас хийх /12,0 сая төгрөг/

Батлагдсан төсөл арга хэмжээний зориулалт Дүрслэл №5



Нийт батлагдсан төсөл, арга хэмжээг зориулалтаар ангилахад барилга, дэд бүтэц 6,0%, их засвар 9,0%, зөвлөх үйлчилгээ 13,0%, авто зам 19,0%, материал, тоног төхөөрөмж 53,0%-ийг тус тус эзэлж байна

Иргэдээс авсан судалгаа Дүрслэл №6



Хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангасан эсэх талаар аймгийн 7 сумын нийт 119 иргэнийг хамруулан судалгаа авахад 58,0% нь сэтгэл хангалуун байна.

В.2. Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт,

хэрэгжилтэд сүүлийн 2 жил дотоод хяналт хийгдээгүй байна.

ТЭЗ-дын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2016, 2017 онуудын ажлын төлөвлөгөөндөө эрсдэлийг нь бага гэж тооцсон тул улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд хяналт хийхээр тусгаагүй байна. Харин 2018 оны төлөвлөгөөнд оруулж ТЭЗ-аар батлуулсан байна.

В.3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудад заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр ашиг, үр өгөөжийг тооцсоны үндсэн дээр төсвийн төлөвлөлтөд тусгах ёстой.

Аудитын явцад улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдэд ТЭЗҮ хийсэн, үр ашиг, үр өгөөжийг тооцоолсон эсэхийг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс тодруулахад эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, чанарын ахиц дэвшлийг хэмжигдэхүйц байдлаар, тоон үзүүлэлтээр нарийвчлан тооцоолж төлөвлөсөн судалгаа, тайлан, мэдээлэл байхгүй байна.

Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29.2-т “Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.” гэж заасан ч иргэдийн бодит хэрэгцээнд тулгуурлаагүй, төслийг хэрэгжүүлэх үе шатны дараалал алдагдсан, дэд бүтцэд холбогдоогүй, ашиглалтын зардал шийдэгдээгүй зэргээс шалтгаалж хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах, ашиглагдахгүй байх асуудал гарч байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Хэрлэн сумын 2-р багийн Спорт заал нь 2015 онд ашиглалтад орсон хэдий ч тухайн үед ашиглалтын зардалгүй гэдэг шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 2017 онд дулааны зардалд 10,0 сая төгрөгийг батлуулсан боловч паар хагарч гадна шугамыг солих шаардлага гарч 2 галчыг 2 сар ажиллуулсаны цалин, нүүрс нийт 930,6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй улирлын шинжтэй ажилласан байна.

- Зүүн бүсийн ахмад настны асрамжийн төв - Барилгын хувьд туршлагатай компани чанартай, сайн гүйцэтгэсэн боловч төвийн инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй учраас ашиглалтгүй байна.



Төсөл, арга хэмжээг газар дээр нь үзэж ашиглагч тал, холбогдох ажилтнуудтай ярилцлага хийлээ.

Хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагыг урьдчилан судлаагүй, шаардлага хангаагүй төхөөрөмж хэрэгсэл нийлүүлэгдсэн, эзэмшигч байгууллага хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, ТАХ-г чанаргүй хийж гүйцэтгэсэн, оны эцэст нийлүүлэгддэг, зориулалтын дагуу ашиглахгүй, орон нутгийн төсвөөр улсын төсөвт байгууллагуудын зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зэрэг шалтгаанаар хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг бууруулж байна.

Тухайлбал:

Чанаргүй хийгдсэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлууд:

- Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг, сумдын нэгдсэн цахим хуудас хийх- Сайтыг холбогдох сумдын мэргэжилтнүүдэд хүлээлгэж өгөөгүй, аймгийн ЗДТГ-ын Мэдээлэл технологийн ажилтан хүлээн авсан, баяжилт муу, ашиглалт аймгийн ЗДТГ, Баяндун, Баян-Уул, Баянтүмэн, Гурванзагал, Хөлөнбуйр сумдаас бусад сумд 2018 онд мэдээлэл хийгээгүй байна.
- Аймгийн залуучуудын нэгдсэн мэдээллийн сайт хийх /ГБХЗХГазар/- Мэдээллийг тогтмол шинэчилж байгаа боловч админ эрх нь байдаггүй болохоор хяналт хийх, хандалтыг харж болдоггүй.

Чанаргүй хийгдсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлууд:

- 8 дугаар сургуулийн халаалтын системийн засвар /Хэрлэн сум/- Насосын холболтыг хийхдээ буруу хийснээс ажиллахгүй.
- Сургуулийн дотуур байрны засвар /Цагаан-Овоо сум/- Зарим цонхны завсраар сийгэж цонх муу хийгдсэнээс дулаан алдсан.
- Сургуулийн барилгын халаалтын тогооны засвар /Халхгол сумын Ялалт баг/- Халаалт өмнөх оноос сайжраагүй, сэргээн засах ажил хийгдээгүй, гагнуур муу хийгдсэнээс ус шүүрсэн

байдалтай байна. Ашиглагч талаас сэтгэл ханамж муу, хангалтгүй хийгдсэн гэсэн үнэлгээ өгсөн.

- Сургуулийн барилгын дээврийн засвар /Халхгол сум/-Сургуулийн заалны дээд талаас ус гоожсон байдалтай байна.



Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу ашиглаагүй төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- АЗДТГ-ын Архивын тасагт шаардлагатай тоног төхөөрөмж- Архивын тасагт шаардлагатай гэж тодотгоолоор батлуулсан боловч архивын тасагт 2, бусад нь аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн тоног төхөөрөмжийг сайжруулах зорилготой ашиглаж байна. 1 scanner шаардлага хангахгүй, удаан ажилладаг гэсэн шалтгаанаар складанд байна.
- Татвар төлөгчдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх, татварын тайланг цахимаар хүлээн авах ажлын хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж /Татварын хэлтэс, сумдын ЗДТГ/- Үйлчилгээнд биш ажилтнууд ашиглаж байна.
- "Нэг цонхны үйлчилгээ"-ний цэгт, шаардлагатай тоног төхөөрөмж /Улсын бүртгэлийн хэлтэс/- 3 үйлдэлт принтер нь нэг цэгийн үйлчилгээнд ашиглаж байна. 2 компьютер, 1 принтер нь нягтлан бодогч, дарга, тасгийн дарга нар ашиглаж байна. УБЕГ дээр бүртгэлийн программ суулгуулах ажил хүлээгдээд байгаа гэсэн тайлбар өглөө.

Бүртгэлд тусгаагүй улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- Цагаан-Овоо сум 1,8 сая төгрөгийн мотоциклыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Хөрөнгийн ашиглалт байхгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажил:

- Цагаан-Овоо, Булган, Чойбалсан, Халхгол, Баян-Уул сумын эмнэлэгт мотоцикл- 2017 оны эцэст нийлүүлэгдсэн гэх шалтгаанаар үйл ажиллагаандаа огт ашиглаагүй байна.



Хөрөнгийн ашиглалт байхгүй орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлууд:

- Боомт орчмын дэд бүтцийг сайжруулах, тохижуулах- Ашиглагч, хэрэглэгч байхгүй.
- Хог тээврийн автомашинд ачих төхөөрөмж суурилуулах /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/- 8 сард хүлээн авсан. Гагнуурчны дутагдлаас болж суурилуулж чадаагүй.гэсэн шалтгаанаар ашиглалтгүй.
- Цас, шороо шүүрдэх төхөөрөмж /Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ/- 8 сард хүлээн авсан. Ковш эвдэрсэн шалтгаанаар ашиглахгүй байгаа.



Орон нутгийн төсвөөр улсын төсөвт байгууллагуудын зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4.1.24-т "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх." гэсэн заалтуудын шаардлагыг хангахгүй байна.

- Татвар төлөгчдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх, татварын тайланг цахимаар хүлээн авах ажлын хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж-50,0 сая төгрөг
- "Нэг цонхны үйлчилгээ"-ний цэгт, шаардлагатай тоног төхөөрөмж /Улсын бүртгэлийн хэлтэс/- 5,7 сая төгрөг
- Бэлэн бус торгуулийн машин худалдан авах /Цагдаагийн газар/-7,5 сая төгрөг

- Аймгийн онцгой байдлын газарт автомашин худалдан авах хөрөнгийн орон нутгаас гаргах дэмжлэг -25,0 сая төгрөг

Тайлант онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна.


Өмнөх оноос шилжиж ирсэн аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын зураг төсөв нь 2009 онд хийгдэж 3,2 тэрбум төгрөгөөр батлагдсан ч он дамжин санхүүжилт хойшлогдсоор 2015 онд 2012 оны ЗТБХБС-ын 181 тушаалаар батлагдсан “Барилгын норм ба дүрэм”-ийн дагуу төсвийг шинэчлэн магадлал хийлгэснээр төсөвт өртөгт өөрчлөлт орж 6,5 тэрбум төгрөгөөр батлагдсан нь он дамжин санхүүжилт хойшлогдсоор ашиглалтад ороогүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил давтагдсаар байна.
2. Хариуцлагагүй байдлаас шалтгаалж чанаргүй, үр дүнгүй ажлууд хийгдсэн байна.
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Аудитаар нийт 1889,2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 12,0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгч ажиллалаа.



ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

31000 Чойбалсан, Дорнод өмнөд,
Утас: 7058-3040, факс: 7058-4683

2018-05-04 № 2/786

тантай _____ -ны № _____ -т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Аймгийн 2017 оны улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын дүгнэлттэй танилцлаа. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тулгарсан тухайн үеийн нөхцөл байдлын талаар дараах тайлбарыг хүргүүлж байна.

1. Дорнод аймаг, Хэрлэн сум 3 дугаар баг "Зүүн бүсийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн өргөтгөл, засвар"-ын ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх хугацаанаас 21 хоногоор хэтэрсэн байна. Ажлын зурагт заасан дулаалгын үе нь хөөсөн хавтангаар дулаалж дээр нь 10 см зузаан цутгалтын ажил хийгдэхээр байсан. Тухайн үед гадна агаарын температур -9°C - 17°C хүйтэн байсан учраас компанид нөхцөл байдлыг танилцуулж, дулаалгын үеийг керамзит мөн шилэн хөвөнгөөр дулаалахаар шийдвэрлэсэн. Керамзит нь орон нутагт нөөц байхгүй байсан учраас Улаанбаатар хот руу керамзит үйлдвэрлэдэг компанид захиалга өгч 12 хоногийн дараа шаардлагатай байгаа дулаалгын керамзит бэлэн болж, ачих, тээвэрлэх явцад 2 хоног алдаж, нийт дээврийн дулаалгын үед 14 хоногийн хугацаа алдагдсан.
2. "Чойбалсан хотын автозамын засвар, арчлалт, тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч тавих" ажлын гэрээний хугацаа 2017.06.30-2017.08.30-ны өдөр байсан. Гүйцэтгэгч "Авто агро" ХХК-аас ашиглалтад хүлээлгэн өгөх хүсэлтийг 09 дүгээр сарын 10-нд ирүүлсний дагуу холбогдох материалуудыг судлан үзэж, ажлын хэсэг 09 дүгээр сарын 28-ны өдөр ашиглалтад хүлээн авах дүгнэлт гаргасан. Иймд гүйцэтгэгчийн ирүүлсэн ашиглалтад хүлээлгэн өгөх тухай албан бичгийн хугацаагаар гэрээний хугацаа 10 хоногоор хугацаа хоцорсон шалтгаан нь үйлчилгээний төвийн зүүн урд, номын сангийн баруун урд талын 4 замын уулзвар хэсэгт ус зайлуулах хоолой сүвгийн зураг төсөв, бүтээц өөрчлөгдөж, ашиглалтыг сэйжруулах, цэвэрлэхэд хялбар болгох зорилгоор лоткийг тагтай болгож өгсөн. Лоткины таг цутгаж, хатаахад хугацаа алдсан. Энэ тухай ажлын хэсгийн хурлаар хэлэлцсэн бөгөөд ажлын үр дүн сайн гэж дүгнээд алданги тооцоогүй болно.
3. "Содномдаржаагийн гудамжнаас Хивс, Ялалтын гудамж дундуур шинээр хатуу хучилттай авто зам тавих, явган зам, гэрэлтүүлгийн хамт /Хэрлэн сум, 10-р баг/-н ажлын гэрээний хугацаа 2017.06.10-2017.07.30-ны өдөр байсан. Гүйцэтгэгч "Авто агро" ХХК-аас ашиглалтад хүлээлгэн өгөх хүсэлтийг 08 дугаар сарын 21-нд ирүүлсний дагуу холбогдох материалуудыг судлан үзэж 08 дугаар сарын 28-ны өдөр ашиглалтад хүлээн авах дүгнэлт гарсан.

01 219

Иймд гүйцэтгэгчийн ирүүлсэн ашиглалтад хүлээлгэн өгөх тухай албан бичгийн хугацаагаар гэрээний хугацаа 21 хоногоор хойшлогдсон. Хугацаа хоцорсон шалтгаан нь Засгийн газрын 336 дугаар тогтоолын дагуу барилгын ажилд Монгол улсын гарал үүсэлтэй бараа материал ашиглана гэж заасны дагуу Улаанбаатар хотын Налайх дүүргийн "Налгар түшиг" ХХК-тай гэрээ байгуулж цемент авч ажиллаж байхад 06 дугаар сарын 28-наас 07 дугаар сарын 20-ныг хүртэл улсын хэмжээнд тасарсан. Мөн орон сууцны 92 дугаар байрны зүүн талын хэсэгт захиалагчийн зүгээс трасст өөрчлөлт оруулсан тул газар чөлөөлж, хашаа буулгаж, барих, авто замын даланг нүүлгэн шилжүүлэх зэрэг нэмэлт ажил хийгдснээс шалтгаалсан.

4. Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг сумдын нэгдсэн цахим хуудас хийх" ажлыг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өгсөн 21 аймаг, 330 сумын Засаг даргын Тамгын газрын вэб сайтыг Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285:2011 стандартад нийцүүлэн шинэчлэх чиглэлийн дагуу Мэдээллийн технологийн чадамжийг дээшлүүлэх Үндэсний төвтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр болж, аймгийн портал вэб сайт болон 14 сумын вэб сайтын ажлыг хийлгэх болсон. /Ажлын байранд ус алдаж, архив устсан тул ирсэн бичгийг хавсаргах боломжгүй болсон./

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 4 дүгээр хуралдааны төсвийн тодотгол хийх үед тухайн ажлын төсөв болох аймгийн портал вэб сайтын үнэ 5,0 сая төгрөг, 14 сумын вэб сайтын үнэ 7,0 сая төгрөгийн 2 ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэх асуудал оруулсан. Хуралдаанаар 2 ажлын төсөв нэгтгэгдэн Хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл арга хэмжээний жагсаалтын 2.14-т 12,0 сая төгрөгийн нэг ажил болон батлагдаж, аймгийн Засаг даргын 2017 оны А/278 дугаар захирамжаар эрх шилжүүлсэн.

Вэб сайтын туршилтын хугацаа дуусахад 330 сумын вэб сайтын линк, шэйр давхцах, зарим нэг гажуудал үүсэх зэрэг асуудал үүсэж байсан. Харин аймгийн портал сайтын хэвийн ажиллагаа жигдрэхгүй, доголдлыг хүсэлт, шаардлагын дагуу засварлахгүй байсан тул Мэдээллийн технологийн чадамжийг дээшлүүлэх Үндэсний төвтэй аймгийн вэб сайтын гэрээг цуцалж, хэд хэдэн компанийг судлан Баамбалби ХХК-тай гэрээ байгуулан вэб сайтыг дахин шинэчлэн засварлаж, нэмэлтүүдийг хийлгэн, одоо туршилтын хугацаанд явж байна.

Иймд дээрх тулгарсан асуудлын үед гэрээний хугацааг чанд баримталж, гэрээг тухай бүр сунган, цаашид Төрийн аудитын газраас өгсөн зөвлөмжийг чанд мөрдөн, хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА  П.БАТ-ӨЛЗИЙ



Саналд өгөх тайлбар:

Аймгийн ЗДТГ-аас 2018 оны 05 сарын 04-ний өдрийн 02/786 тоот албан бичгээр 4 заалт бүхий тайлбар ирүүлснийг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн дараах өөрчлөлтийг хийлээ.

Тайлбар 1-3.

Саналыг хүлээн авч, захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын тайлбар, нотлох баримтуудыг үндэслэн гэрээний хугацаа хэтэрсэн хоногт ногдох алдангид төлбөрийн акт тогтоохгүй байхаар шийдвэрлэж тайланд өөрчлөлт орууллаа.

Тайлбар 4.

Саналыг хүлээн авч, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.3, 4.1.8 дахь заалтуудыг үндэслэн зөрчил гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр тогтов.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Д.Мянганбаяр, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Н.Базаррагчаа, ГХБХБГ-ын дарга Д.Дамдинбазар нарт:

1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж, улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг хүргүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасны дагуу тооцоо, судалгаанд үндэслэх.
2. Захиалагчийн хяналт, хариуцлагыг сайжруулж, ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолын 3 дугаар зүйл, СС-ын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4 дүгээр зүйлийг тус тус баримтлан ажиллах.
3. Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөө, үр өгөөжийг төлөвлөж, үр ашгийг дээшлүүлж, ашиглагдахгүй байгаа 466,0 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ч.Нэргүйд:

1. Гүйцэтгэгчийг сонгох шалгаруулах ажиллагаанд ТБОНӨХБАУХА хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Аудитаар тавигдсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 01/37-ГАГ-ААН-2018-01-1А

Нөвбэлсэн хот

Хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15.2 дугаар зүйлд тодорхойлогдсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудитор, дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 2011 стандартыг хангасан аймаг сумдын нэгдсэн цахим хуудас хийх" нийт 12,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулж, уг гэрээ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 40.5, Сангийн сайдын 2012 оны 81 тоот тушаалаар батлагдсан журамд заасан шаардлагад нийцээгүй, вэб сайтыг сумд бүрэн хүлээж аваагүй, үндсэн цэсний ашиглалт байхгүй байгаа бөгөөд ТЕЗ-аас санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 24.4 дэх "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5 дахь "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.", Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 4.20 дахь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.3-д "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн.", 4.1.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д "Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, гүйцэтгэлийн аудитаар материаллаг

шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сэхилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

Дээрх хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн, зөрчил гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцон ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2018 оны 06 дүгээр сарын 30-ны дотор аймгийн Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

ДАРГА БОГООД ТЭРГҮҮЛЭХ ЛУДИТОР
Б.БОЛОРТУУЛ

ЛУДИТЫН МЕНЕЖЕР В.ЦЭНГЭЛМАА

ЛУДИТОР З.ГАНСҮХ

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
М.БАДАМСҮРЭН

* Ант, албан шаардлагын биелэлт хангагдажгүй тохиолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлдэн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн явцах цал хүмүүсэнд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажилдоо нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ," хэж явсны дагуу зориулсан албан тушаалтанд хариуцлага тооцуулахыг эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 1д.

Чойбалсан хот

Г Гүйцэтгэлийн аудитын тайланг Т
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

11 039

Аймгийн Тэргүүлэх аудитын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 2018.05.10 тоот тушаалын хэвсрэг




Албан шаардлагын жагсаалт

2018.05.10.

№	Байгууллагын нэр	Гүнцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн ахны утга	Мөнгөн дүн
1	Аймгийн ЭДТГ	ГАГ-2018-01-ГА, ГАГ-ДОА-2018-01-ГА	Жарнуулага тооцуулах тухай	12000000,0
	Нийт дүн			12000000,0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ


ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР  В.ЦЭНГЭЛМАА


БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  Б.ДЭЛГЭРМАА

АУДИТОР  М.УХААНБИЛЭГ

АУДИТОР  Я.ЗОРИГ

ГЭРЭЭТ АУДИТОР  З.ГАНСҮХ

ГЭРЭЭТ АУДИТОР  Г.ХОНГОРЗУЛ